

## ТАНИЛЦУУЛГА

### *Арбитрын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийн талаар*

Арбитр нь үүссэн маргааныг талуудын тохиролцсоны дагуу, маргаан таслах хараат бус бүрэлдэхүүний өмнө шийдвэрлэх арга юм. Монгол Улсад арбитртай холбоотой харилцааг зохицуулсан БНМАУ-ын Арбитрын байгууллагын тухай, Гадаад худалдааны арбитрын тухай зэрэг хуулиуд үйлчилж байсан бөгөөд 2003 оноос хүчин төгөлдөр үйлчилж байгаа Арбитрын тухай хууль хэрэгжиж эхэлсэн билээ. 2003 оны Арбитрын тухай хуулийг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон улсын худалдааны эрхзүйн комиссын Олон улсын худалдааны арбитрын тухай Загвар хууль (цаашид “Загвар хууль” гэх)–д нийцүүлэх чиглэлийг баримтлан боловсруулсан боловч Монгол Улс одоог хүртэл Загвар хуулийг нутагшуулсан орны жагсаалтад бүртгэгдээгүй байдаг.

Арбитрын тухай хуульд 2007 оны 08 дугаар сарын 03-нд, 2011 оны 02 дугаар сарын 10-нд, 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт орсон боловч зарчмын шинжтэй өөрчлөлт тусгагдаагүй.

Арбитрын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг өөрийн орны онцлог, НҮБ-ын Загвар хуульд нийцүүлэн, бусад улсын шилдэг туршлагыг судлан, доор дурдсан шинэлэг зохицуулалт тусган боловсрууллаа. Үүнд:

### **1. Арбитрын ажиллагааны харьяалал**

Арбитрын ажиллагааны харьяалал (place of arbitration, seat of arbitration)-ыг арбитрын хуралдаан болох газар гэсэн утгаар 2003 оны хуульд тусгагдсаныг өөрчиллөө. Энэ нэр томъёо нь олон улсад төдийгүй Монгол Улсад арбитрын маргаан шийдвэрлэж байгаа байршлыг илэрхийлж хэрэглэгддэг байсан бол орчин үед арбитрын эрх зүйн хэм хэмжээ, арбитраар маргаан шийдвэрлэх ажиллагаа явуулах, арбитрын шийдвэр зэргийг тодорхой нэг нутаг дэвсгэрт үйлчилж байгаа хуулийн зохицуулалттай уялдуулан ойлгох болсон.

Арбитрын ажиллагааны харьяалал нь арбитрын хуралдаан, уулзалт хийх, гэрч асуух, шинжээч томилох, үзлэг хийх зэрэг тодорхой ажиллагаа явуулах газраас өөр ойлголт юм. Энэхүү харьяалал нь тухайн арбитрын ажиллагаанд үйлчлэх эрх зүйн хүрээг тодорхойлдог. Тухайлбал, арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс байна гэж талууд тохиролцсон тохиолдолд ч арбитрын хуралдаан, уулзалт хийх, гэрч асуух, шинжээч томилох, үзлэг хийх зэрэг тодорхой ажиллагаа Монгол Улсаас өөр улсад явуулж болох бөгөөд харин арбитрын үндсэн шийдвэр гаргах газар нь Монгол Улс байх бөгөөд уг шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх, гүйцэтгэхээс татгалзах зэрэг асуудлыг Монгол Улсын эрх бүхий шүүх энэ хууль болон процессын хуулийнхаа дагуу хэлэлцэж шийдвэрлэх юм.

### **2. Шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээ**

Загвар хуульд шинээр тусгасанарбитрын бүрэлдэхүүн шийдвэрийнхээ биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авч болох нарийвчилсан зохицуулалтад нийцүүлэн “Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ, урьдчилсан тогтоол” гэсэн бүлгийг шинээр боловсрууллаа.

Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрын бүрэлдэхүүн арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авч болох бөгөөд тэр нь арбитрын бүрэлдэхүүнээс аль нэг талд үүрэг болгосон арга хэмжээ /түр арга хэмжээ/ байхаар тусгалаа. Шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээний зарим төрөл Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдан, практикт хэрэгжиж байгаа бөгөөд энэ төсөлд тусгасан арга хэмжээ нь илүү өргөн хүрээтэй арга хэмжээнүүд юм.

Арбитрын шийдвэрээр үүрэг хүлээх магадлалтай тал нь арбитрын үндсэн шийдвэр гарахаас өмнө өмч хөрөнгөө захиран зарцуулах зэргээр шийдвэрийг хэрэгжих боломжгүй болгох тохиолдол байдаг. Иймд арбитрын шийдвэр бодит байдал дээр хэрэгждэг байх нөхцөлийг хангах үүднээс цаг хугацааны хувьд эцсийн шийдвэр гарахаас өмнө цаг хожиж хамгаалалтын шинжтэй арга хэмжээ авах бүрэн эрхийг арбитрын бүрэлдэхүүн эдэлдэг байх боломжийг хангахад энэхүү түр арга хэмжээний ач холбогдол оршино. Эдгээр арга хэмжээнд дараахь төрлийн арга хэмжээ орно. Үүнд:

а. Маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа нөхцөл байдлаа хэвээр хадгалах, эсхүл сэргээх арга хэмжээ

Талуудад, жишээ нь одоогийн байгаа нөхцөл байдлаа хэвээр хадгалж, компани татан буулгахгүй байх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх гэх мэт үүрэг хүлээлгэж болох юм. Түүнчлэн гэрээний нэг тал болох хувьцаа эзэмшигч маргаан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх үед хувьцаагаа бусдад шилжүүлэх алхам хийгдэж эхэлсэн бол хувьцаагаа эргүүлэн авахыг даалгах үүргийг холбогдох талд хүлээлгэх замаар одоогийн байгаа нөхцөл байдлаа сэргээх үүрэг хүлээлгэж болно.

б. Одоогийн, эсхүл учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, эсхүл арбитрын ажиллагаанд бэрхшээл учруулах үйлдэл хийхгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Энэ арга хэмжээ нь хариуцагч этгээдэд тухайн цаг үед нөгөө талд учруулсан болон цаашид учирч болох хохирлыг нэмэгдүүлэх үйлдэл хийхгүй байхыг үүрэг болгосон арга хэмжээ юм. Тухайлбал, барилгын ажил гүйцэтгэгч нь хугацаандаа үүргээ биелүүлээгүйгээс захиалагчид тодорхой хэмжээний хохирол учруулсан бөгөөд уг компани дахин өөр ажил эхлүүлэх нь нэхэмжлэгчид учрах хохирлыг нэмэгдүүлэх магадлалтай гэж арбитрын бүрэлдэхүүн үзвэл хоёр дахь ажлын гэрээг байгуулахгүй байхыг даалгаж болох юм. Түүнчлэн хоёр дахь гэрээг байгуулах тухай мэдээлэл байхгүй ч гэсэн тийм гэрээ байгуулахаас урьдчилан сэргийлж гэрээ байгуулахгүй байхыг даалгаж болно. “Арбитрын ажиллагаанд бэрхшээл учруулах үйлдэл хийхгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх”-дээ гадаадад болон орон нутагт удаан хугацаагаар явахгүй байж, арбитрын хуралдаанд биечлэн оролцохыг үүрэг болгож болох юм.

в. Арбитрын үндсэн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардлагатай байж болох хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах

Энэ арга хэмжээнд доор дурдсан арга хэмжээ хамаарах юм:

- Түр арга хэмжээгээр үүрэг хүлээгч талын эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх;
- Түр арга хэмжээгээр үүрэг хүлээгч талаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох;
- Түр арга хэмжээгээр үүрэг хүлээгч талын дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох;
- Нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд урьдчилан оруулахыг үүрэг болгох зэрэг арга хэмжээ байж болно.

Мөн хөрөнгөд эрхлэн хамгаалалт менежмент томилох гэх мэт хөрөнгө хамгаалах, үнэ цэнг бууруулахгүй, ашигтай удирдах арга хэмжээ авах, хөрөнгийггуравдагч этгээдийн хадгалалтад шилжүүлэх үүрэг хүлээлгэх зэрэг хамаарч болох юм.

г.Маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой, уг маргаантай холбоотой байж болох нотлох баримтыг хамгаалахарга хэмжээ

Жишээ нь, гэрээ, талуудын хооронд харилцаж байсан захидал, мэдээлэл, эсхүл мэдээллийн технологийн тухайн үеийн шийдэл зэргийг хадгалах, гаргуулан авах гм арга хэмжээ байж болох юм.

Эдгээр түр арга хэмжээг талууд биелүүлэх үүрэгтэй ба хэрэв биелүүлэхгүй бол уг түр арга хэмжээ авах шийдвэрийг аль улсад гарснаас үл хамааран шүүхэд өргөдөл гаргах замаар гүйцэтгүүлж болохоор тусгалаа.

### **3.Санхүүгийн баталгаа**

Төсөлд тусгасан “санхүүгийн баталгаа” гэдэгт арбитр, шүүхээс маргааны аль нэг талаас гаргуулсан хэрэгжих боломжтой үүрэг, амлалт, үүргийн гүйцэтгэлийг хангах тодорхой арга хэмжээг ойлгоно.Энэхүү баталгаа нь Иргэний хуулийн 234 дүгээр зүйлд зааснаас илүү өргөн агуулгатай бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа аргыг багтааж байгаагийн дээр тухайн талын төрөл бүрийн амлалт хамаарна.

Арбитрын бүрэлдэхүүн нь түр арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан талд уг арга хэмжээтэй холбогдуулан зохих санхүүгийн баталгаа гаргахыг шаардаж болох бөгөөд энэ нь уг түр арга хэмжээгээр үүрэг хүлээсэн буюу үүрэг хүлээж болох талд “тухайн арга хэмжээг аваагүй тохиолдолд үндсэн шийдвэрийн дагуу төлүүлж болох хохирлыг хангалттай барагдуулах боломжгүй бөгөөд уг хохирлын хэмжээ нь тухайн арга хэмжээг авсны улмаас уг арга хэмжээнд холбогдох этгээдэд учирч болох хохирлоос үлэмж их байх” нөхцөлийн дагуу тооцсон хохирлоос илүү их хэмжээний хохирол бодитойгоор учирвал уг түр арга хэмжээг авахуулах хүсэлт гаргасан тал өөрийн гаргасан санхүүгийн баталгаагаараа хариуцдаг байхад чиглэсэн зохицуулалт юм.

#### **4.Зардал хохирол гаргуулах**

Тухайн нөхцөл байдалд түр арга хэмжээ авах, урьдчилсан тогтоол гаргах шаардлагагүй байсныг арбитрын бүрэлдэхүүн хожим тогтоосон бол уг арга хэмжээ авах тухай хүсэлт, урьдчилсан тогтоол гаргуулах тухай хүсэлт гаргасан тал хариуцлага хүлээх нөхцөлийг тодорхойлсон зохицуулалт шинээр тусгалаа.

#### **5.Цахим хэлбэрээр хийх хэлэлцээр**

Загвар хуульд тусгасан шинэлэг зохицуулалтыг судлан, цахим харилцаа холбоогоор арбитрын гэрээг байгуулахад заавал тоон гарын үсэг шаардахгүй байж болох нөхцөлийг төсөлд тусгалаа. Энэ шинэ зохицуулалттай уялдуулан зохих нэмэлтийг Иргэний хуульд оруулахаар мөн хуулийн төсөл боловсрууллаа.

#### **6.Дампуурал**

Арбитрын хэлэлцээр бүхий гэрээний аль нэг талтай холбоотой дампуурлын хэрэг үүссэн тохиолдолд арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр үргэлжлэх эсэхийг хэрэг гүйцэтгэгч, эрх хүлээн авагч шийдвэрлэнэ. Хэрэв дампуурлын ажиллагааг зохион байгуулж байгаа хэрэг гүйцэтгэгч, эрх хүлээн авагч нь талуудын маргаан үүсгэж байгаа гэрээнээс татгалзаагүй бол арбитрын хэлэлцээр нь тухайн этгээдийн хувьд хүчин төгөлдөр хэвээр байна. Хэрэв хэрэг гүйцэтгэгч, эрх хүлээн авагч тухайн гэрээнээс татгалзвал маргааныг дапуурлын хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх дампуурлын хэрэгтэй хамтад нь шийдвэрлэхээр зохицуулалт тусгалаа.

Дээр дурдсан шинэлэг зохицуулалтаас гадна хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн Загвар хуульд нийцэхгүй байгаа зарим зохицуулалтыг шинэчлэн найруулсан бөгөөд дэвшилтэт зохицуулалтыг хадгаллаа.

Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг нь Монгол Улсын Дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, МХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын ба үндсэний арбитр, бусад хуульч, эрдэмтэн, арбитрч нарын бүрэлдэхүүнтэй ажилласан бөгөөд төслийг боловсруулах явцад хэлэлцүүлэг, олон улсын бага хурал удаа дараа зохион байгуулсан ба холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн саналыг авч төсөлд тусгалаа.

Хуулийн төслийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Олон улсын худалдааны арбитрын тухай Загвар хуульд нийцэж байгаа эсэх талаар НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын саналыг авсан бөгөөд уг төсөл Загвар хуульд нийцэж байгаа тухай урьдчилсан санал дүгнэлт ирсэн болно.

### **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**